



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2022 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 683

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Боловсрол, шинжлэх ухааны яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 7 нэрийн, нийт 568,658,183.00 (таван зуун жаран найман сая зургаан зуун тавин найман мянга нэг зуун наян гурван) төгрөгийн балансын үнэ, 168,057,930.00 (нэг зуун жаран найман сая тавин долоон мянга есөн зуун гучин) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг “Боловсролын мэдээллийн технологийн төв” улсын төсөвт үйлдвэрийн газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн, “Боловсролын мэдээллийн технологийн төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Тодгэрэл нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2022 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн  
682... дугаар тогтоолын хавсралт

**БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМНЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, "БОЛОВСРОЛЫН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ТӨВ"  
УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАРТ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ (ширхэг)	Нийт балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг	Шинэчлэн тогтоосон үнэ	Цаашид ашиглах хугацаа (жил)
				(төгрөг)				
1	Газарзүйн мэдээллийн системийн программ хангамж	2021.01.01	1.00	495,500,000.00	148,650,000.00	346,850,000.00		
2	Зөөврийн компьютер	2020.12.03	1.00	1,749,500.00	524,850.00	1,224,650.00		
3	Телевизор HD /panasonic/	2014.01.02	1.00	6,980,143.00	6,980,143.00	-	3,500,000.00	5
4	Мэргэжлийн түвшиний дэлгэц	2021.12.31	1.00	2,150,940.00	215,094.00	1,935,846.00		
5	Суурин компьютерийн процессор	2021.12.31	1.00	27,288,800.00	2,728,880.00	24,559,920.00		
6	Суурин компьютерийн процессор	2021.11.03	1.00	27,288,800.00	3,183,963.00	24,104,837.00		
7	Хурлын сандал	2014.01.02	14.00	7,700,000.00	5,775,000.00	1,925,000.00		
				<b>568,658,183.00</b>	<b>168,057,930.00</b>	<b>400,600,253.00</b>	<b>3,500,000.00</b>	<b>-</b>
<b>Нийт дүн</b>				(таван зуун жаран найман сая зургаан зуун тавин найман мянга нэг зуун наян гурван)	(нэг зуун жаран найман сая тавин долоон мянга есөн зуун гучин)	(дөрвөн зуун сая зургаан зуун мянга хоёр зуун тавин гурван)	(гурван сая таван зуун мянган)	-